



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А007

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, 1, 2 дахь заалтын төсөл, арга хэмжээг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг “Баруун бүсийн зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ (Б.Батжаргал)-т, 3, 4 дэх заалтын төсөл, арга хэмжээг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ (Б.Галхүү)-т тус тус үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 13,274,400,000.0 (арван гурван тэрбум хоёр зуун далан дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийг “Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “Б.1”-д заасан “Хотын гол болон туслах гудамж замуудын ээлжит арчлалт, засвар”-ын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725023004

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 04 ны өдрийн
17607 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Хотын гол болон туслах гудамж замуудын ээлжит арчлалт, засвар (Сонгинохайрхан дүүрэг-1)	2025	2025	3,510.4	3,510.4
2	Хотын гол болон туслах гудамж замуудын ээлжит арчлалт, засвар (Сонгинохайрхан дүүрэг-2)	2025	2025	3,738.5	3,738.5
3	Хотын гол болон туслах гудамж замуудын ээлжит арчлалт, засвар (Баянзүрх дүүрэг-1)	2025	2025	3,079.0	3,079.0
4	Хотын гол болон туслах гудамж замуудын ээлжит арчлалт, засвар (Баянзүрх дүүрэг-2)	2025	2025	2,946.5	2,946.5
	ДҮН			13,274.4	13,274.4



رقم ۵۰
رقم ۵۰
رقم ۵۰

امپدانس مریضی در مستقیق پسوندی در اندرپیچ مریضی مستقیق در پیچ مریضی . رنجهای
 امپدانس مریضی (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)
 رنجهای مریضی (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)
 اندرپیچ مریضی (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)
 امپدانس مریضی (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)

۷) (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)
 اندرپیچ مریضی (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)
 امپدانس مریضی (۱-۲) (۳-۴) (۵-۶) (۷-۸) (۹-۱۰)



نسخه

اندازه مریضی
 امپدانس مریضی